

*Л.Сэлэнгэ (Монголын Ногоон Намын дарга асан, Цөмийн аюулгүй Монгол улсын төлөө үндэсний хөдөлгөөний тэргүүн)*

## **ЭРҮҮЛ САРУУЛ УХААН ЭХ ДЭЛХИЙГ СҮЙРЛЭЭС АВАРНА<sup>1</sup>**

**Үзэл бодол, итгэл үнэмшил, зорилго нэгт  
Та бүхний энэ өдрийн амрыг айлтгая.**

**Өнөөдөр Та бид хүн төрлөхтөн, байгаль дэлхийгээ цөмийн аюулаас аврах чухал түүхийг хамтдаа бичилцэж байна. Та бид энэхүү түүхэн үйл явдлын гэрч, бас түүнийг бүтээгчид юм.** Ингээд та бүхэнд Монголд гадны цөмийн хаягдал булшлах талаар гарсан яриа, АЦС барих, уран олборлох бодлого ямар шатандаа явж байгаа талаар товч ярья.

“2010 оны 9 дүгээр сард АНУ-ын Эрчим хүчний дэд сайд Понеман Монголд айлчлах үеэр **Монгол улсад цөмийн хаягдал хадгалах байгууламж барих төслийг** анхлан хэлэлцэж эхэлсэн байдаг. Үүнээс тавхан сарын дараа 2011 оны 2 дугаар сард Япон, Америк, Монголын албаны хүмүүс Вашингтонд уулзаж эхний шатны гэрээ хэлэлцээр хийжээ. Үүний дараагаар Монголоос цөмийн түлш авах хүсэлтэй Арабын Нэгдсэн Эмират улс дээрх гэрээ хэлэлцээрт нэгдсэн байна”<sup>2</sup>. Америк, Япон, Монгол гурван улсын дунд албан бус гэрээ хэлэлцээр явагдаж байгаа тухай Америкийн “Global Security Newswire” сэтгүүл 2011 оны 3 дугаар сарын 30-нд нийтэлсэн бөгөөд Японы Майничи сонин мөн энэ талаар мэдээлсэн.

Монголын улсын Шинжлэх ухааны байгуулагыг олон жил толгойлж байсан нэгэн академич “Японы 50 гаруй АЦС-ийн бий болгосон асар их хог бий. Түүнийг тодорхой хугацаанд Монголын говьд авч ирээд булж хадгалж болно. Цөмийн хаягдлыг нутаг дэвсгэр дээрээ байрлуулах нь эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Хэрвээ манай улс цөмийн хог хаягдлыг нутаг дэвсгэр дээрээ байрлуулах аваас зуун жил цахилгаанаар хангах атомын цахилгаан станц үнэгүй бариад өгөх болно”<sup>3</sup> гэж Монголын өдөр тутмын нэгэн сонинд өгсөн ярилцлагандаа хэлсэн байгаа.

Цөмийн хаягдал бол маш том бизнес хэмээн эрээ цээргүй ярьдаг их хурлын гишүүд манайд байдаг. Монгол хүний язгуур эрх ашиг, улс орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдлаас үнэтэй бизнес гэж байдаг юмуу? Монголын газар нутагт Япон, Өмнөд Солонгос, Тайваны АЦС-ын хаягдал авчирч булшлах асуудлаар Global Security Newswire, The Mainichi Daily News, Kyodo News, Известия зэрэг нэр хүндтэй хэвлэл мэдээллийн байгууллагууд дараалан мэдээлж үүний дагуу Монголын ногоонтууд

<sup>1</sup> “Цөмийн эрчим хүчгүй дэлхий ертөнцийн төлөө Yokohama 2012” олон улсын конференц дээр тавьсан илтгэл

<sup>2</sup> <http://mdn.mainichi.jp/mdnnews/news/20111015p2a00m0na023000c.html>, мөн golomt.org-оос үзнэ үү.

<sup>3</sup> Өдрийн сонин, 2011 он 4 дүгээр сарын 18

тууштай эсэргүүцэж эхэлсэн билээ. Бид 5 сарын хугацаанд нийт 20 гаруй удаа Цөмийн хаягдал булшлахыг эсэргүүцсэн хэвлэлийн хурал хийлгэж байсан нь Монголын бүх телевизүүд, өдөр тутмын сонингууд, веб сайтад тавигдаж байлаа. Мөн цөмийн хаягдлыг эсэргүүцсэн олон мянган хүнтэй фейсбүүкийн бүлгүүд бий болсон юм. 2011 оны 6 дугаар сарын 11-нд Фүкүшимагийн Дайчи АЦС-д осол гарсны 3 сарын ойн өдөр Монголын Ногоон нам Улаанбаатарын төв талбай дээр АЦС барих, цөмийн хаягдал булшлахыг эсэргүүцсэн гарын үсэг цуглуулах ажил зохион байгуулсан. 8 дугаар сард АНУ-ын дэд Ерөнийлөгч Жой Байденийг Монгол улсад албан ёсоор айлчлахад Монголын Ногоон Нам Монголд цөмийн хаягдал булшлах АНУ-ын төлөвлөгөөг эсэргүүцсэн жагсаалыг улс төрийн бусад нам, иргэний хөдөлгөөнүүдтэй хамтарч зохион байгуулсан.

2011 оны 9 дүгээр сарын 11-нд Фүкүшимагийн ослын 6 сарын ойн өдөр “Цөмийн аюулгүй Монгол улсын төлөө” үндэсний хөдөлгөөн зохион байгуулж Монгол улсад АЦС барих, уран олборлох, цөмийн хаягдал байршуулахыг эсэргүүцсэн гарын үсэг цуглуулах аяныг эхлүүлж нийт 6000 гаруй хүний гарын үсэг цуглуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдад ил захидлын хамт хүргүүлсэн.

Бидний хийсэн тэмцлийн үр дүнд Монгол улсын Ерөнхийлөгч 2011 оны 9 дүгээр сарын 13-нд “Монгол улсын нутагт гадны цөмийн хаягдал булшлахыг хориглосон зарлиг гаргасан. Үүнээсээ долоохон хоногийн дараа НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 66 дугаар чуулганы индэр дээрээс Монгол улс гадны цөмийн хаягдлыг өөрийн нутагтаа булшлуулахгүй гэдгээ мэдэгдсэн юм. Гэсэн хэдий боловч Монголын Засгийн газар Япон, Франц, Хятад, АНУ, ОХУ, Австрали, Канад зэрэг улс орнуудтай хийсэн Цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах гэрээ хэлэлцээрүүдээ эргэн харах, Атомын цахилгаан станц барих, уран олборлох бодлогоосоо татгалзах хүсэл эрмэлзэлгүй байна.

Монгол улс цацраг идэвхт ашигт малтмал олборлох, цөмийн эрчим хүч ашиглах зорилгоор 2009 онд “Цөмийн энергийн тухай хууль” баталсан. Энэ хуулийг УИХ-ын байнгын хороогоор урьдчилсан хэлэлцүүлэг огт хийлгүйгээр ганцхан өдрийн дотор батлан гаргасан гэвэл Та итгэх үү? “Харин энэхүү хууль батлагдсан яг тэр өдөр нь буюу 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр тухайн үеийн Монгол улсын Ерөнхий сайд, ЦЭГ-ын даргын хамт Япон улсад оччихсон Японы ерөнхий сайд Таро Асотой Цөмийн энергийн салбарт хамтран ажиллах талаар хэлэлцээр хийж, Японы Байгалийн нөөц, эрчим хүчний газартай цөмийн энергийн салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулж явжээ”<sup>4</sup>.

“Уранаар мэргэшсэн боловсон хүчин байхгүй”<sup>5</sup> Монгол улс ураны үйлдвэртэй болох гэж байгаад Та бас итгэх үү? Манай улс социализмын үед хуучнаар ЗХУ-д цөмийн физикийн чиглэлээр цөөн тооны мэргэжилтэн бэлтгэж байсан боловч яг уранаар мэргэшсэн мэргэжилтэн байдаггүй. Гэтэл Монголын Засгийн газар “Ураны

<sup>4</sup> “Цөмийн энергийн бизнест хэн хэн оролцож байна вэ?”, golomt.org-ийн Цуврал №1., 11.09.2011.

<sup>5</sup> О.Чулуун “Монголчууд уранаа ашиглах боломжтой ч өнөөдөртөө нөхцөл бүрдээгүй байна”. CoCo.mn, 2011 оны 7 дугаар сарын 8.

боловсруулах үйлдвэр дөрөвийг барихаар төлөвлөөд байна”<sup>6</sup>. Монгол улсын Цөмийн энергийн газар одоогийн байдлаар боловсон хүчнээ хэрхэн бэлтгэж байна вэ гэвэл “олон улсын сургалт семинарт оролцуулах, туршлага судлах, танилцуулах уулзалтанд хамруулах зэргээр мэргэшлүүлж байна”<sup>7</sup>. Ийм байдлаар сургалтанд хамрагдсан боловсон хүчнийг ураны үйлдвэрт ажиллах мэргэшсэн боловсон хүчин гэж үзэж болох уу?

Монгол орны нийт газар нутгийн 70 хувь нь ураны хайгуулын судалгаанд хамрагдсан байна. Манай улс 1,4 сая тонн ураны нөөцтэй. Ураны нөөцөөрөө дэлхийд 15 дугаарт жагсдаг. Одоогоор гадаад дотоодын 18 компанид цацраг идэвхит ашигт малтмалын 109 тусгай зөвшөөрөл олгожээ.

2011 оны 12 дугаар сарын эхээр “Францын Арева компани Монгол улсад уран олборлох туршилтын ажлаа амжилттай дуусгаж дараагийн шатны олборлох, үйлдвэрлэх ажлаа эхлүүлэх гэж байгаа тухайгаа зарлалаа”<sup>8</sup>. Дэлхийн ураны найман том акул компаний тав нь Монголд орж ирсэн хэмээн хэвлэл мэдээлэлд бичиж байна. Эх оронд маань экологийн дайн эрчээ аван дэгдэж байгаа яг энэ цаг үед дээр нь нэрмээд улс үндэстнийг маань үндсээр нь сөнөөх цөмийн бизнес ид цэцэглэж байна. “Монгол улс сая гаруй тонн уранаа цөлмүүлж оронд нь үхлийн тоосонцор, цөмийн хаягдалтай үлдэхэд Монголчуудын хувьд үлгэр, нар хоёр зэрэг жаргана”<sup>9</sup>.

2012 оноос АЦС барьж эхлүүлэх Монгол Улсын Засгийн газрын бодлого хэвээрээ байна. Өнгөрсөн оны 8 дугаар сард Монгол Улсын Цөмийн энергийн газар Японы Цөмийн энергийн агентлагтай хамтран АЦС барих асуудлаар хамтарсан семинар зохион байгуулсан. Хамгийн сүүлд 2011 оны 12 дугаар сарын 23-нд “Цэвэр энергиэр ирээдүйг бүтээх нь” сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа. АЦС барих газар нутгаа хүртэл сонгосон<sup>10</sup> тухайгаа мэдээлж байна. Уранаа осол аюулгүй олборлох технологи байхгүй, цөмийн түлшний үйлдвэр барих хөрөнгөгүй, түүнд ажиллах мэргэжилтэй ажилтангүй хирнээ уран олборлож, боловсруулах үйлдвэр барина, АЦС барих хөрөнгө мөнгөгүй, түүнийг ажиллуулах өндөр мэргэжилтэй боловсон хүчингүй, АЦС ажиллуулж ирсэн туршлагагүй, осол аваар гарвал зохицуулах гамшгийн менежмент, дэд бүтэц байхгүй<sup>11</sup> атлаа АЦС барина хэмээн манай төрийн өндөрлөгүүд хөөрцөглөж гадаад дотоодгүй ярьж, санал санаачлага гаргаж явдаг болсон. Монголчууд бид Монгол улсын 1,5 сая квадрат метр нутгийг маш том бизнес, бөөн бөөн мөнгө гэж хардаг эрх баригчидтай болсон байна. Бидний эх орныг газартай нутагтай нь, хүнтэй малтай нь худалдаж чаддаг хүрэл чулуун зүрхтэнүүдийн гарт

<sup>6</sup> Цөмийн энергийн газар “Цэвэр энергиэр ирээдүйг бүтээх нь” эрдэм шинжилгээний хурлын тайлан. 2011 оны 12 дугаар сарын 23.

<sup>7</sup> Цөмийн энергийн газар “Цэвэр энергиэр ирээдүйг бүтээх нь” эрдэм шинжилгээний хурлын тайлан. 2011 оны 12 дугаар сарын 23, хуудас 13.

<sup>8</sup> Өнөөдөр сонины 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн дугаарт “‘АРЕВА’-ТАЙ ХУВААЛЦАХ МОНГОЛЫН ЭРХ АШИГ БУЮУ 40:60” нэртэй нийтлэлээс ишлэв.

<sup>9</sup> Амарлин “Цөмийн үлгэр буюу Монгол улсын мөхөл”, <http://golomt.org/2011/08/12/nuclearmyth/#more-2136>

<sup>10</sup> Цөмийн энергийн газар “Цэвэр энергиэр ирээдүйг бүтээх нь” эрдэм шинжилгээний хурлын тайлан. 2011 оны 12 дугаар сарын 23.

<sup>11</sup> Амарлин “Цөмийн үлгэр буюу Монгол улсын мөхөл” нийтлэлээс ишлэв. <http://golomt.org/2011/08/12/nuclearmyth/#more-2136>

бидний хувь заяа байна. Иймд бидний тэмцэл дуусаагүй. Миний эх орныг цөмийн аюулаас ангид байлгахад Та бүхний дэмжлэг туслалцаа маш их хэрэгтэй байна. Хэрвээ тууштай тэмцэж чадвал амжилтанд хүрч болох юм байна гэдгийг бид өөрсдийн туршлагаараа олж мэдсэн. Бүгдээрээ хамтдаа Цөмийн аюулгүй дэлхий ертөнцийн төлөө чадах бүхнээ хийцгээе. Хүн төрлөхтөн алдарт Египетийн пирамид, Ла Маншийн хонгилыг барьж, интернетийг нээж, сансрыг эзэмшиж, саран дээр буусан. Хүмүүс бид энэ бүхний **ялагч нь** байлаа. Хүн төрлөхтөн ганцхан зүйлийн өмнө **ялагдагч нь** болсон юм. Энэ бол **цөмийн технологи**. Гэхдээ бид үүнийг ялж чадна. Бид цөмийн технологийг оюун ухаанаараа бий болгосон, бас зөвхөн эрүүл саруул оюун ухаанаараа ялна. **Түүнийг ялах арга тун энгийн. Энэ бол АЦС-аас татгалзах.** АЦС-ыг дэмжигчид цөөхүүлээ, харин эсэргүүцэгчид олуулаа. Тиймээс бид ялна.

Yokohama, Japan

2012 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр